

АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Хугацаа: Хуанлийн 123 хоног, ажлын 85 өдөр

Эхлэх хугацаа: 2025 оны дугаар сарын-ний өдөр

Дуусах хугацаа: 2025 оны дүгээр сарын-ний өдөр

Зорилго	“Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа”-г гүйцэтгэн үр дүнг мэдээлэх.
Үндэслэл	- УИХ-ын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.1.6-д “Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа”-г хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаанд жил бүр зохион байгуулахаар төлөвлөсөн. - Азийн Сан нь тус судалгааг Сант Марал Сантай хамтран 2006-2019 онуудад улс орон даяар, давтамжит байдлаар зохион байгуулсан. Энэхүү судалгааг дахин хийснээр авлигын цар хүрээ, авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг, тэдгээрт гарч буй өөрчлөлт болон төр, засгийн зүгээс авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний ахиц дэвшлийг үнэлэх, өмнөх жилүүдийн үр дүнтэй харьцуулах, цаашдын бодлого, арга хэмжээг боловсруулахад чухал эх сурвалж болно. - Иймд Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хангах хүрээнд АТГ-аас энэхүү судалгааны ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж, өнгөрсөн хугацаанд гарсан өөрчлөлт, үр дүнг харьцуулан дүгнэж, үйл ажиллагаанд ашиглах зорилготой.
Түүвэр	Судалгааг нийслэл Улаанбаатар хот болон бүс нутгийн төлөөлөл хамруулан зохион байгуулна. Судалгаанд нас, хүйс, боловсрол, орлогын түвшин, оршин суугаа газар нутгийн ялгаатай бүлгүүдийг тэнцвэртэй хамруулах бөгөөд түүвэр нь улс орны хэмжээнд олон нийтийн хандлага, ойлголтыг төлөөлөхүйц байх шаардлагатай. Түүврийн хэмжээ, дизайныг тогтоохдоо дараах шалгуурыг хангасан байна. Үүнд: - Түүврийн алдааны магадлал, стандарт хазайлт 5 хувь буюу итгэх түвшин 95 хувь байх ; - Газар нутгийн бүсчлэл, хүн амны нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлтийн төрөл зэргээр тархаан тооцоолох боломжтой байх. - Түүвэрт холбогдох талуудын төлөөллийг бүрэн хамруулах;
Зөвлөхийн гүйцэтгэх ажил	- Судалгааны асуулгыг орчин үеийн судалгааны онол, арга зүйд тулгуурлан судалгааны ажлын зорилго, онцлогт нийцүүлж шинэчлэн боловсруулах; - Судалгаанд оролцогчдод судалгааны ажлын танилцуулга, ач холбогдлын талаар танилцуулж, өгөгдлийг тоон болон чанарын арга ашиглан цуглуулах;

	• Өгөгдлийн шинжилгээг хийх; /SPSS болон бусад судалгааны программыг ашиглан гүйцэтгэх/ • Шинжилгээнд үндэслэн ажлын даалгаварт заасан зорилгыг хангахуйц тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд үр нөлөө бүхий санал, дүгнэлт бүхий интерактив тайлан боловсруулах; • Судалгааны үр дүнг танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгуулж, цаашид хэрэгжүүлэх хөтөлбөрийг санал болгох; • Судалгааны тайланг нэгтгэн боловсруулж хэвлэн цахим хувилбарын хамт хүлээлгэн өгөх;
Зөвлөхөд тавигдах шаардлага	Ерөнхий шаардлага: Зөвлөхийн баг нь дараах мэргэжил, туршлага бүхий үндсэн 4-өөс доошгүй гишүүнтэй байна. • Социологи, статистик болон бусад холбогдох нийгмийн шинжлэх ухааны чиглэлийн мэргэжилтэй байх; • Монгол Улсын засаглалын тогтолцоо, хууль, эрх зүйн орчны талаар маш сайн мэдлэгтэй байх; • Англи хэлний бичгийн ур чадвар эзэмшсэн байх; • Ижил төстэй судалгаа шинжилгээ, үнэлгээний ажил удирдан зохион байгуулж, үр дүн гаргасан байх (давуу тал болно); Бусад: Судалгаа, шинжилгээний ажил 3-аас доошгүй жил эрхэлсэн, ажлын дадлага, туршлагатай, өмнө нь хууль тогтоомж, бодлогын баримт бичиг боловсруулж байсан туршлагатай, ажлын даалгаврыг бүрэн гүйцэтгэх хангалттай мэдлэг, ур чадвартай зөвлөх байх;
Тайлангийн хуваарь	• Гэрээ байгуулж ажил эхэлснээс хойш хуанлийн 7 хоног тутамд ажлын явцыг цахимаар тайлагнаж байна;
Судалгааны тайланд тавигдах техник шаардлага	• Судалгааны ажил нь агуулгын хувьд харилцан уялдаатай, иж бүрэн, шинжлэх ухааны судалгааны тодорхой арга зүй /түүвэрлэх, нэгтгэх, анализ хийх, загварчлах, харьцуулах зэрэг/-д үндэслэсэн, эрэлт хэрэгцээнд нийцсэн, онол-практикийн ач холбогдол бүхий байна. • Судалгаа ажил /тайлан, төсөл, судалгаа, санал зөвлөмж/-ын хэлбэржүүлэлт /формат/ нь төрийн албан хэрэг хөтлөлтийн журам, судалгааны ажилд тавигдах нийтлэг шаардлагад нийцсэн, хэл зүйн болон утга найруулгын алдаагүй байна. • Судалгааны үр дүнг хэлэлцүүлгээр танилцуулах ажлыг зохион байгуулна.
Санал ирүүлэх	Шалгаруулалтыг сонгох аргаар явуулна. Дээрх шаардлагыг хангасан этгээд дараах бичиг баримтыг бүрдүүлж ирүүлнэ: • Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт /албан бичгээр/; • Ажлын даалгаврыг гүйцэтгэх бүрэлдэхүүний мэдээлэл; • Боловсрол, ур чадварын талаарх мэдээлэл; • Ажлын туршлагын хураангуй болон уг даалгаврыг гүйцэтгэх чадвартай болохыг нотолсон баримт бичиг; • Сүүлийн 5 жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын талаарх танилцуулга /хамгийн багадаа 2 ажил/; • Даалгаврыг гүйцэтгэх хугацаа болон үнийн санал, зардлын тооцоо;